

“ТАНЫ САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД: МӨНГӨӨ ХЭРХЭН ЗӨВ УДИРДАХ ВЭ?” ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ 2 ДАХЬ УДААГАА АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Монголын Банкны Холбоо санаачлан дэлхийн хуримтлалын өдрийг тохиолдуулан олон нийтийн санхүүгийн боловсролд зориулсан “Таны санхүүгийн боловсролд: Мөнгөө хэрхэн зөв удирдах вэ?” нээлттэй арга хэмжээг 2017 оны 10-р сард зохион байгуулсан билээ. Энэхүү арга хэмжээ нь олон нийтэд хадгаламжийн ач тусыг ойлгуулсан, оролцогчдын сэтгэлд хүрсэн, үр дүнтэй болж өнгөрсөн тул МБХ, Unread хамтран Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, Голомт банк, Улаанбаатар хотын банк, Богд банк болон Цэцээ Гүн ротаракт клубын дэмжлэгтэйгээр 2018 оны 3-р сарын 31-ний өдөр Корпорейт Конвейшн Центрийн Концертийн танхимд 2 дахь удаагаа амжилттай зохион байгууллаа.



Олон нийтийн санхүүгийн боловсролд зориулав.

ТАНЫ САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД: МӨНГӨӨ ХЭРХЭН ЗӨВ УДИРДАХ ВЭ? №2

АФА Академийн гүйцэтгэх захирал Ш.Амартүвшин

БИ ХЭРХЭН ХАДГАЛДАГ ВЭ?

Бизнес, банк санхүүгийн салбарын төлөөлүүд оролцоно

Корпорейт Хотел энд Конвейшн Центр
3 сарын 31, 09:00 цагт

Такс: 5,000 төгрөг

Нээлттэй арга хэмжээ нь “Мөнгөө хэрхэн зөв удирдах вэ?” гэсэн 2 хэсгээс бүрдсэн лекц, “Би хэрхэн хадгалдаг вэ?” панел ярилцлага болон азтан шалгаруулах арга хэмжээ гэсэн хэсгүүдээс бүрдсэн юм. Арга хэмжээнд нийт 20-50 насны 1100 орчим хүн оролцлоо.

Лекцийг “АФА академи”-ийн гүйцэтгэх захирал, амьдралын дасгалжуулагч Ш.Амартүвшин удирдан явуулсан бөгөөд мөнгийг өөрийн ирээдүйдээ зориулан хэрхэн төлөвлөх, сүл зардлаа хэмнэх, санхүүгээ зөв удирдах, санхүүгийн зөв төлөвлөгөөтэй амьдрах зэрэг хэрэгцээтэй, үнэт зөвлөгөөнүүдийг онцолсон юм.



Лекцийн үеэр нийгэмд үлгэр дууриалал үзүүлж буй санхүүгийн салбарын лидерүүд, бизнесийн салбарын төлөөлүүд болох Монголын Банкны Холбооны дэд ерөнхийлөгч О.Банзрагч, Вагнер Ази Автомотив ХХК-ийн гүйцэтгэх захирал Гаррет Вилсон, Lhatouг брэндийн үүсгэн байгуулагч Д.Хулан болон АФА академийн үүсгэн байгуулагч Аксел Фишер нар




ХУРАЛ УУЛЗАЛТ
СУРГАЛТЫН
ЗОРИУЛАЛТТАЙ
ТАНХИМУУДЫГ ТҮРЭЭСЛЭН
ХАМТАРЧ АЖИЛЛАНА

Дэлгэрэнгүй мэдээллийг
11-32 35 81 99081142

“Би хэрхэн хадгалдаг вэ?” сэдвийн хүрээнд нээлттэй ярилцаж, өөрсдийн туршлагаас нээлттэй хуваалцлаа.

Арга хэмжээний үеэр Голомт банк, УБХБ, Капитрон банк, ҮХОБ болон Богд банкүүд өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулан шууд данс нээх, дансандаа мөнгө нэмэх зэрэг боломжийг олгосны зэрэгцээ арга хэмжээг дэмжин ажилласан Голомт банк, Улаанбаатар хотын банк, Богд банкүүдийн зүгээс нийт 10 азтанг шалгаруулан өөрсдийн гарын бэлгийг гардууллаа.

Арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажилласан нийт байгууллагууд болон арга хэмжээнд идэвхтэй оролцсон хүмүүстээ дахин талархал илэрхийлье.

“PROFESSIONAL SERIES” ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ АМЖИЛТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Монголын Банкны Холбоо болон Банк санхүүгийн академиас хамтран зохион байгуулдаг “Professional series” өглөөний цуврал уулзалт 2018 оны 3 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдлаа.

2018 оны анхны уулзалтын зочноор Худалдаа, хөгжлийн банкны Олон улсын болон байгууллагын харилцааны газрын захирал Б.Эрхэмбаяр оролцож, “Гадаад харилцаа, бизнес хамтын ажиллагааг хөгжүүлэх нь” сэдвийн хүрээнд өөрийн туршлагаасаа хуваалцан сонирхолтой яриа өрнүүлсэн юм.



Б.Эрхэмбаяр нь 2010 оноос эхлэн ХХБ-ны гадаад бизнес харилцааг хариуцан ажилласан ба чөлөөт цагаараа эмэгтэйчүүдийн нийгмийн асуудал, банк санхүү, эдийн засгийн чиглэлээр нийтлэл, өгүүлэлүүд бичдэг бөгөөд уулзалтын үеэр гадаад харилцаанд юуг чухалчлан анхаарах, хэрхэн урт хугацаанд хадгалж үлдэх зэрэг сонирхолтой сэдвүүдийг ярилцлаа.

Бидний урилгыг хүлээн авч сонирхолтой яриа хийсэн Б.Эрхэмбаяр захирал болон цаг заваа гарган хүрэлцэн ирсэн нийт зочиддоо талархал илэрхийлье.

ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЛЭЭ

Төрөөс Мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах Үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоолын 3 дахь хэсэгт “Зээлийн хүү бууруулах стратеги боловсруулах” үүргийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон Санхүүгийн Зохицуулах Хороонд даалгасан. Үүний дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн А-241 дугаар тушаалаар “Зээлийн хүүг бууруулах стратегийн баримт бичгийн төсөл” боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монголбанкны бодлогын газрын захирлууд, Монголын Банкны Холбоо, эдийн засгийн судалгаа, шинжилгээний хүрээлэнгүүдийн төлөөлөл багтсан бөгөөд ажлын хэсэг 6 сарын турш ажиллаж, “Зээлийн хүүг бууруулах үндэсний стратегийн төсөл”-ийг бэлэн болгоод байна. Тус төсөлд судлаач, эдийн засагчдын саналыг авах хэлэлцүүлгийг 2018 оны 3 дугаар сарын 20-ний өдөр зохион байгууллаа.

MBA Events
ГАР УТАСНЫ АППЛИКЕЙШН

MBA-оос зохион байгуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааны үнэмлэхүй нэг дүрсээ авч болно!

ОНЦЛОХ

ШИНЭЛЭГ
MBA нь үйл ажиллагаануудын талаарх мэдээ, мэдээллийг байгальд хамтгаар цаг алдалгүй өөрийн гар утаснаас авч ашиглаж болно.

ХҮРТЭМЖТЭЙ
MBA-оос зохион байгуулж, зохион байгуулж буй болон эдгээр зохион байгуулдаг арга хэмжээнд, үйл ажиллагааны үнэмлэхүй нэг дүрсээ авч болно.

ХЭРЭГЛЭЭНД НИЙЦСЭН
Үйл ажиллагааны талаар санал илгээх, асуулт тавих, арга хэмжээ уриалах, ан хэлбэрд буй мэдээллийг мөрт хэргийн талаарх мэдээллийг авах, сонирхож байгууллагуудтай хамбоо барих болно.

БАЙГАЛЬД ЗЭЛТЭЙ
Зохион байгуулагдаж буй арга хэмжээтэй холбоотой материал, мэдээллийг цаас ашигтайгаар авах, хэргийн болно.

iOS Scan this code & download your phone

Android Scan this code & download your phone



Стратегийг тоймлон онцолбол, зээлийн хүүг бууруулахдаа макро эдийн засгийн орчинг бүрдүүлэх, бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, банкуудын эрсдэл даах чадвар, үр ашиг болон засаглалыг сайжруулснаар зээлийн хүүг бууруулах боломжтой гэж үзэж байна. Энэ хүрээнд стратегийн 11 зорилтыг тодорхойлж, стратеги тус бүрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан байна. Зээлийн хүүг бууруулах стратегийн 11 зорилт нь:

- . Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах – инфляцийн зорилтот түвшинг хангах
 - . Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, улсын секторын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах
 - . Төсвийн сахилга батыг хангах, макро бодлогын үялдааг сайжруулах
 - . Эдийн засгийг төрөлжүүлэх, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх
 - . Бодлогын хүүний коридорыг ашиглан хүүний сүвгийн нөлөөг сайжруулах
 - . Санхүүгийн долларжилтыг бууруулах
 - . Хүчтэй санхүүгийн системтэй болох, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх
 - . Зээлийн мэдээллийн сан, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх
 - . Зээлийн эрсдэлийг бууруулах, энэ чиглэлд эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох
0. Банкуудын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх
1. Төрийн болон санхүүгийн байгууллагуудын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах зэрэг болно.



Хэлэлцүүлэгт оролцогсдын зүгээс зээлийн хүүг бууруулахад төв банк санаачилга гаргаж ажиллаж буйд талархалаа илэрхийлэв. Түүнчлэн хүүг бууруулахад дан ганц Төв банк гэлтгүй төр засгийн бүхий л институциуд хамтран ажиллах шаардлагатай гэдгийг онцоллоо. Мөн зээлийн өр төлбөр барагдуулахтай холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагааны зардал өндөр, хэт их цаг хугацаа зарцуулагдаж буй нь хүүг өндөр тогтоох бас нэг шалтгаан болж байна. Тийм учраас хууль эрх зүйн орчин, шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай гэдгийг онцоллоо. Инфляцийг бууруулах замаар эх үүсвэрийн зардлыг бууруулах, шаардлагатай бол Төв

банкнаас банкуудад тогтоож буй заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулах нь зээлийн хүүг бууруулахад бас нэгэн чухал дэмжлэг болно гэх зэргээр оролцогсад байр сууриа илэрхийлэв.

Мэдээллийн эх сурвалж: www.mongolbank.mn

“PROFESSIONAL SERIES №2” ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Монголын Банкны Холбоо болон Банк санхүүгийн академиас хамтран зохион байгуулдаг “Professional series” өглөөний цуврал уулзалт 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдлаа.

Тус уулзалтын ээлжит зочноор “Оюу Толгой Хяналт” ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Сүхгэрэл оролцож, “Банкин дахь гомдол шийдвэрлэх механизм ба олон улсын туршлага” сэдвээр ярилцан өөрийн туршлагаасаа хуваалцлаа.



Д.Сүхгэрэл нь 2010 оноос эхлэн Оюу Толгой Хяналт ТББ-ын гүйцэтгэх захирлаар ажилласан ба гомдлын удирдлага, олон улсын банкуудын гомдлын механизмын ашиглалт, байгаль орчин ба нийгмийн стандартын хэрэгжилтийн хяналтын хүрээнд олон жил ажиллаж, мэргэшсэн бөгөөд гомдол барагдуулах механизмын хүрээнд арвин туршлагатай юм.

Бидний үрилгыг хүлээн авч сонирхолтой яриа хийсэн хатагтай Д.Сүхгэрэл болон цаг заваа гарган хүрэлцэн ирсэн нийт зочиддоо талархал илэрхийлье.

АЗИЙН БАНКНЫ ХОЛБООНЫ ЭРХЛЭН ГАРГАДАГ “ABA NEWSLETTER” СЭТГҮҮЛИЙН

4 ДҮГЭЭР САРЫН ДУГААР ГАРЛАА

Монголын Банкны Холбоо нь Азийн Банкны Холбооны гишүүн байгууллагын хувьд олон талаар хамтран ажилладаг. Азийн Банкны Холбооноос 2 сар тутамд цахим хэлбэрээр өөрийн сэтгүүлийг эрхлэн гаргадаг бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын сэтгүүлийг илгээсэн байна. Хавсралтаас цахим сэтгүүлийг үзнэ үү.

МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБОО

This message contains graphics. If you do not see the graphics, click [here](#) to view the full e-newsletter.

This newsletter was sent to you because you are registered to receive updates and special promotions from MBA. To opt out, click [here](#).